

ЯЛ ТЭНССЭН ЭТГЭЭДЭД ХЯНАЛТ ТАВИХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

JURISDICTION OF SUPERVISION OF CONVICTS REGULATION AND IMPLEMENTATION



Б.Эрдэнэчимэг

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэрээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага, хэрэгжилтийг хангахад хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд тулгамдаж буй асуудлыг гарган, шийдвэрлэх арга замыг тодорхойлохыг зориloo.

Товч утга: Албадлагын арга хэмжээний ойлголт, төрөл, шүүхээс албадлагын арга хэмжээ авагдсан шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага, хэрэгжилтийг хангахад хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд тулгамдаж буй асуудлыг гарган, шийдвэрлэх арга замыг тодорхойлохыг зориloo.

Abstract: The purpose of this paper is to identify the concepts and type of coercive measures, the responsibility to be imposed on the person who fails to comply with the court's decision, and the amplementation of the law and legal regulations, and to identify ways to solve them.

Түлхүүр үсг: Ял тэнсэгдсэн этгээдэд хяналт тавих эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт

Keywords: legal regulation of supervision of convicted persons, implementation

Хоригоос өөр төрлийн ял эдлүүлэх алба нь хоригоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг гүйцэтгэх ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавих, нэгдсэн тоо бүртгэл, судалгааг хөтлөх, үйл ажиллагааны талаар гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх, чиглэлийн хүрээнд чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Хоригоос өөр төрлийн буюу олон улсын эрх зүйд альтернатив ял хэмээн нэрлэгддэг нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхээр тогтоосны дараа

нийгмээс тусгаарлаж, тусгаарласан байранд тогтоосон хугацаанд хорихгүйгээр тодорхой эрхийн хязгаарлалт тогтоох хэлбэрээр хэрэгждэг.⁵⁸

Дэлхий нийтийн жишгээс хараад хорих ялаас аль болох татгалзан бага хэрэглэх болж, хоригоос өөр төрлийн ялд ач холбогдол өгөн, үр нөлөөг дээшлүүлэхэд албадлагын арга хэмжээ илүү ач холбогдолтой гэж үзэх болсон. Өөрөөр хэлбэл хоригоос бусад төрлийн ялыг үндсэн ялын шинжтэйгээр оногдуулан, нэмж албадлагын арга хэмжээг түлхүү хэрэглэдэг байна.

Мэдээлэл технологийн 21 дүгээр зуунд шинжлэх ухааны бүхий л салбарын олон амжилт, ололтууд шинээр нэвтэрч, нийгэм, эдийн засаг, эрх зүйн орчин хурдацтай хувьсан өөрчлөгдөж, хууль зүйн шинжлэх ухаан тэр дундаа эрүүгийн эрх зүйн ялын бодлогын хэрэгжилтийг хангахад аль болох хуучин хэв шинж, биечилсэн хяналтаас татгалзаж, олон шинэлэг аргачлал, дэвшилтэд техник, технологиудыг туршиж, шат дараалалтайгаар ашиглаж эхэлсээр байна.⁵⁹

Албадлагын арга хэмжээ авагдсан хүнд хяналт тавих журмыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар тогтооно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 19 дүгээр бүлэгт шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага албадлагын арга хэмжээний биелэлтэд хяналт тавихаар тусгасан.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа байгууллагагүй нутаг дэвсгэрт тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хяналт тавьж, биелэлтийн талаар 30 хоног тутам шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бичгээр мэдэгдэнэ” гэж заасан.

Мөн шийдвэр гүйцэтгэгч үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн талаар хуульд заасан аргаар мэдээлэл авч болно.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Эрүүгийн хариуцлага нь энэ хуульд заасан ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэнэ⁶⁰ гэж заасан.

Албадлагын арга хэмжээ гэдэг нь гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдсон этгээдэд шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан Эрүүгийн хуульд заасан ялын бус шинжтэй, төрийн албадлагын арга хэмжээний төрлийг хэлэх бөгөөд эрүүгийн хариуцлагын нэг хэлбэр боловч ялаас ялгагдах онцлог шинжтэй. Албадлагын арга хэмжээ нь ялын төрөл биш. Эрүүгийн хариуцлагын зорилгод нийцүүлэн гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь нотлогдсон хүнд нөлөөлөх шинжтэй арга хэмжээг ойлгоно.

Албадлагын арга хэмжээний төрлийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангид хуульчилсан ба албадлагын арга хэмжээг хэрэглэх үндэслэл, журам, нөхцөлийг мөн тусгайлан заасан.

Шүүх эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж албадлагын арга хэмжээ хэрэглэх, эсхүл оногдуулсан ял дээр нэмж албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

⁵⁸ Ц.Очгэрэл. торгох ялын хэрэгжилт ба түүний хэрэгжилтэд анхаарах асуудал. “Хууль сахиулах үйл ажиллагаа Онол практикийн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2017. 411 дахь тал

⁵⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэлгэл эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 180 дахь тал

⁶⁰ Монгол Улсын Эрүүгийн хууль 2015 он

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.2 дугаар зүйлд албадлагын арга хэмжээний төрлийг дараах байдлаар хуульчилсан.⁶¹ Үүнд:

Насанд хүрсэн хүнд:

1. Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ
2. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ
3. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ

Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ гэдэг нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлагын хүрээнд хуульд заасан хэд хэдэн үүрэг хүлээлгэж, эрхийн хязгаарлалтыг тогтоож байгаа албадлагын арга хэмжээний нэг төрөл⁶² юм. Уг арга хэмжээг шүүх оногдуулсан ял дээр нэмж эсхүл ял оногдуулахгүйгээр тэнсэж хэрэглэхээр зохицуулсан байна. Агуулгын хувьд албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд үүрэг хүлээлгэх, тодорхой эрхийг хязгаарлах гэсэн хоёр хэлбэртэй.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл, байдлыг харгалзан

1. Гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах,
2. Зан үйл засах, хөдөлмөрийн дадал олгох сургалтад хамрагдах,
3. Тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх,
4. Оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх үүрэг хүлээлгэж болно.

Мөн шүүх дараах хязгаарлалтыг тогтооно.

1. Тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах,
2. Галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох,
3. Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох,
4. Тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглох.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ гэдэг нь сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй үедээ гэмт хэрэг үйлдсэн эсхүл хэрэг хариуцах чадвартай байхдаа гэмт хэрэг үйлдсэн боловч шүүхээр хэрэг шийдвэрлэх үед буюу ял эдэлж байхдаа сэтгэцийн өвчтэй болсон, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан эсхүл өөр бусад хүнд өвчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон этгээдэд авах эрүүгийн эрх зүйн нөлөөллийн арга хэмжээний нэг төрөл³ юм.

Хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ гэдэг нь гэмт хэрэг үйлдэж, олсон хөрөнгө, орлогыг эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учирсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулж буй албадлагын арга хэмжээний нэр төрөл юм.

Гэмт хэрэг үйлдэж олсон орлого гэж Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж, шууд болон шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник хэрэгслийг ойлгоно.

Өсвөр наасны хүнд:

⁶¹ Монгол Улсын Эрүүгийн хууль 2015 он

⁶² С.Нарангэрэл. Эрүүгийн хуулийн ерөнхий анги 2020 он

1. Өсвөр насны хүнд ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах,

2. Эрүүгийн хуульд заасан үндэслэл журмаар шүүгдэгчид оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэхгүйгээр хүмүүжүүлэх боломжтой гэж шүүх үзвэл тодорхой хугацаа зааж үүрэг болгосон агуулгатай болзол тавьж ялыг биечлэн эдлүүлэх явдлыг түдгэлзүүлж буйг ойлгоно.

3. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ,

Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж нэг жилээс гурван жил хүртэлх хугацаагаар хянан хүмүүжүүлэх албадлагын арга хэмжээний төрөл юм.

Хуулийн этгээдэд:

1. Эрх хасах албадлагын арга хэмжээ,

Хуулийн этгээдэд жилээс найман жил хүртэлх хугацаагаар нэг эсхүл хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах эсхүл эрх хасах албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

2. Татан буулгах албадлагын арга хэмжээ

Хуулийн этгээдийг Эрүүгийн хуульд заасан тохиолдолд татан буулгах албадлагын арга хэмжээ хэрэглэнэ. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар гэмт хэрэг үйлдсэн бол хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгаж болно.

3. Хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ,

Хуулийн этгээдийн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлого, бусдад учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хуулийн этгээдийн хөрөнгө орлогоос албадан гаргуулна.

Хорих ялын гүйцэтгэлийн холбоотой албадлагын арга хэмжээ

1. Хорих ялаас хугацааны өмнө суллаж, хяналт тогтоох

2. Хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөх

3. Хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

4. Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх гэсэн төрлүүдтэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189.9 дэх хэсэгт “Шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 189.1-д заасан хугацаа, хуваарь, шүүхээс хүлээлгэсэн үүргийг зөрчсөн этгээдэд албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгуулж, ял оногдуулах тухай саналыг прокурорт гаргана” хэмээн хуульчилсан нь мөн л материаллаг хуулийн тодорхойгүй заалтад үндэслэсэн гэж үзнэ.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх уг шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулна” гэсэн бөгөөд энэхүү хэсэгт “өмнө үйлдсэн гэмт хэрэгт нь” гэсэн нэмэлт оруулах шаардлагатай байна гэж судлаач миний бие үзсэн.

Учир нь уг арга хэмжээг ялтай хамт эсхүл тэнсэх, ял хойшлогдсон хүнд хэрэглэхээр хуульчилсан бөгөөд нэгэнт ял оногдуулчихсан тохиолдолд дахин ял оногдуулах, хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн бол тэнсэгдсэн гэмт хэрэгт нь ял оногдуулах нь зүйн хэрэг билээ.

Шүүхээс үүрэг хүлээлгэх, эрхийн хязгаарлах албадлагын арга хэмжээ авах нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тодорхой төрлийн ял эдлүүлэх ажиллагааны явцад ялтны хүлээх үүрэгтэй давхцаж буйг тэмдэглэх хэрэгтэй.

Жишээ нь:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 187.1, 187.2 дахь хэсэгт тэнсэгдсэн болон ял хойшлогдсон этгээдийн хүлээх үүргийг хуульчилжээ. Үүнд:

1. гадаадад зорчих, цагаачлахыг хориглох
2. оршин суугаа засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийг 7 хоногоос дээш хугацаагаар орхин явах тохиолдолд зөвшөөрөл авах,
3. 30 хоног тутам нэг удаа биечлэн ирж, бүртгүүлэх,
4. оршин суух газар болон эрхлэх ажил, албан тушаал өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр мэдэгдэж байх,
5. байнга оршин суух газраа очсоноос хойш ажлын 3 өдрийн дотор нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанад мэдэгдэх;
6. сар тутамд шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанад, оршин суугаа нутаг дэвсгэрт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгжгүй бол харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад бүртгүүлэх, шүүхээс хүлээлгэсэн үүргийн биелэлтийн талаар тайлбар гаргах;
7. байнга оршин суух хаягаа өөрчлөх тохиолдолд хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанад, оршин суугаа нутаг дэвсгэрт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгжгүй бол харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад мэдэгдэх, шинээр суурьших нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанад, эсхүл цагдаагийн байгууллагад мэдэгдэх;
8. байнга оршин суугаа газраасаа 7 хоногоос илүү хугацаагаар явах, гадаадад зорчих бол хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанад, оршин суугаа нутаг дэвсгэрт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгжгүй бол харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад мэдэгдэх;
9. хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, цагдаагийн байгууллагын алба хаагч, шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг биелүүлэх.

Түүнчлэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан этгээдийн хувьд:

1. байнга оршин суух газраа очсоноос хойш ажлын 3 өдрийн дотор нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанад мэдэгдэх;
2. сар тутамд шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанад, оршин суугаа нутаг дэвсгэрт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгжгүй бол харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад бүртгүүлэх, шүүхээс хүлээлгэсэн үүргийн биелэлтийн талаар тайлбар гаргах;
3. байнга оршин суух хаягаа өөрчлөх тохиолдолд хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанад, оршин суугаа нутаг дэвсгэрт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгжгүй бол харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад мэдэгдэх, шинээр суурьших нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанад, эсхүл цагдаагийн байгууллагад мэдэгдэх;
4. байнга оршин суугаа газраасаа 7 хоногоос илүү хугацаагаар явах, гадаадад зорчих бол хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанад, оршин суугаа нутаг дэвсгэрт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгжгүй бол харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

5. хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, цагдаагийн байгууллагын алба хаагч, шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг биелүүлэх зэргийг хуульчилснаас хараад шүүх гэмт хэрэг үйлдсэн хүнд хорих ялыг тэнссэн эсхүл хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан хүнд дээр дурдсан үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрэглэсэн тохиолдолд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хүлээх үүрэг, эрхийн хязгаарлалт нь давхардан хэрэглэгдэх болж байна.

Түүнчлэн албадлагын арга хэмжээний гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах, зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэсэн тохиолдолд энэхүү үүргийг хэрхэн гүйцэтгэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй байгаа нь хуулийн хийдэл яахын аргагүй мөн.

Дүгнэлт

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба нь хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг гүйцэтгэх ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавих, нэгдсэн тоо бүртгэл, судалгааг хөтлөх, үйл ажиллагааны талаар гаргасан өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх, чиглэлийн хүрээнд чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Дэлхий нийтийн жишгээс хараад хорих ялаас аль болох татгалзан бага хэрэглэх болж, хорихоос өөр төрлийн ялд ач холбогдол өгөн, үр нөлөөг дээшлүүлэхэд албадлагын арга хэмжээ илүү ач холбогдолтой гэж үзэх болсон. Өөрөөр хэлбэл хорихоос бусад төрлийн ялыг үндсэн ялын шинжтэйгээр оногдуулан нэмж албадлагын арга хэмжээг түлхүү хэрэглэдэг байна.

Эрүүгийн хариуцлагын нэгдмэл тогтолцоотой улс орны хувьд эрүүгийн хуульдаа ял, ялын бус эрүүгийн хариуцлагын төрлүүдийг хуульчлан тогтоож, шүүхийн практикт түгээмэл хэрэглэдэг бол дуалист тогтолцоотой улс орнуудын хувьд гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахын зэрэгцээ албадлагын арга хэмжээг давхар хэрэглэдэг онцлогтой байна.

Дэлхийн ихэнх улс Эрүүгийн хуульд заасан тодорхой төрлийн ялаас гадна албадлагын арга хэмжээг түгээмэл хэрэглэж байна. Шүүхээс оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэхээс зайлсхийж, тэднийг гэр бүл, нийгэмд хүмүүжүүлэх боломжийг олгох зорилгоор тодорхой үүрэг хүлээлгэж, тусгай байгууллагын хяналтад байлгаж, хяналтын хугацаанд нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх, тусалж, дэмжих, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж ажилладаг байна.

Манай улс дэлхий нийтийн жишгийн дагуу Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинчлэн баталж, зарчмын шинжтэй өөрчлөлтүүдийг оруулсны нэг нь тэнсэх албадлагын арга хэмжээний төрөл хэлбэрийг хуульчилсан нь байна. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдэж байгаа Эрүүгийн хуульд ял оногдуулахгүйгээр албадлагын арга хэмжээ хэрэглэх зохицуулалтыг хуульчлан тогтоосон.

Гэмт хэрэг үйлдсэн хүний үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан шүүх ял оногдуулахгүйгээр шийдвэрлэсэн бол эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах үүднээс тодорхой эрхийн хязгаарлалт тогтоож, албадлага хэрэглэдэг.

Албадлагын арга хэмжээний мөн чанар нь нэг талаас гэмт хэрэг үйлдсэн хүнд ял шийтгэлийг гарцаагүй байх, нөгөө талаас энэрэнгүй ёсны зарчимтай холбогддог.

Санал

Албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага, хэрэгжилт сэдвийн хүрээнд дараах саналыг дэвшүүлэн гаргаж байна. Үүнд:

✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн баталж, зарчмын шинжтэй өөрчлөлтүүд оруулснаар шүүхээс хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг түлхүү хэрэглэх болсон. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч харьялах нэгжийг хариуцан 160 ялтан, этгээдүүдэд хяналт тавихаар норматив батлагдсан боловч өнөөдрийн байдлаар дунджаар 200 гаруй ялтан этгээдүүдэд хяналт тавин ажиллаж байна. Цаашид ажлын ачаалал нэмэгдэх төлөвтэй байх учир хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны ахлах шийдвэр гүйцэтгэгч, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч, албадлагын арга хэмжээ авагдсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх шийдвэр гүйцэтгэгч гэж тус тусад нь хуваарилан олон тооны асуудал шийдвэрлэх

✓ Зан үйл засах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд сургалт явуулах төрийн болон төрийн бус байгууллагын хамтын үйл ажиллагаа нь хуулийн зохицуулалттай ч орон нутаг тэр дундаа аймаг нийслэлээс алслагдсан газарт тусгай зөвшөөрөл бүхий магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага байдаггүй тул сургагч багш, хариуцсан мэргэжилтнийг бэлтгэх,

✓ Албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбоотой Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 186 дугаар зүйлийн 186.2.5. “Тогтоолын биелэлтийг хойшилуулсан этгээдийн сахилга, засрал хүмүүжисл, шүүхээс даалгасан үүргийн биелэлтийн талаар хяналтын хувийн хэрэгт 30 хоног тутам тэмдэглэл хийх” гэж шийдвэр гүйцэтгэгчийн үүргийг хуульчлан заасан ч мөн хуулийн 188 дугаар зүйлийн 188.4 дэх хэсэгт “Ялан тэнссэн, тогтоол биелүүлэхийг хойшилуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй эсхүл шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг барын хугацаанд хоёр түүнээс дээш удаа зөрчсөн, эсхүл хориглолт, хязгаарлалтыг зөрчсөний улмаас хүн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолт хохирол учирсан, эсхүл тогтоолын биелэлтийг хойшилуулсан этгээд үүргээ биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч 5 хоногийн дотор тэнссэн, тогтоол биелүүлэхийг хойшилуулсан шийдвэрийг хүчингүй болгуулжс, ял оногдуулах саналаа прокурорт хүргүүлнэ” гэж заасан нь хуулийн хийдэл болж, хяналтад байгаа этгээдэд ял завших, шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх хугацаа хожих сар бүрийн бүртгэлээ тогтмол хийлгэхгүй байх боломж болж байх тул хуулийн уг зохицуулалтыг нарийвчлан тусгах ёстой гэсэн саналыг гаргаж байна.

✓ Тэнсэгдсэн этгээдэд хяналт тавих, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах зайлшгүй шаардлага тулгардаг. Нэн ялангуяа шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгж хэсэг ажилладаггүй орон нутагт ШШГТХ-н 162.6, 180.3, 187.2, 239.5 дахь хэсэгт зааснаар Цагдаагийн алба хаагч шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавьж ажилладаг.

✓ Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан 2017.12.14-ны өдрийн а/260, а/242 тоот тушаалаар батлагдсан ШШГБ, Цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журмын дагуу ШШГБ-ын харьяа нэгжгүй хэсэгт тэнсэгдсэн этгээдэд хяналт тавих, шүүхийн

шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд Цагдаагийн алба хаагч хяналт тавьж ажиллаж байна. Дурдсан хуулийн заалт түүнд нийцүүлэн гаргасан уг журмуудын хувьд хийдэлтэй, зөрчилдөөнтэй заалтууд багагүй байгааг дурдвал: Уг журмын хоёр. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамтран ажиллах” гэсэн хэсэгт тэнсэгдсэн этгээдэд хяналт тавих шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар дурдагдаагүй нь Цагдаагийн байгууллага хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох боломжгүй мэт ойлголтыг төрүүлж байна. Учир нь материаллаг хуульд энэхүү хоёр ойлголтыг тус тусад нь, ШШГТХ-н 188, 189 дүгээр зүйлүүдэд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тус бүрд нь хуульчлан тодорхойлсон бөгөөд энэ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тусдаа төрөл учраас энэхүү журамд тусгагдах ёстой гэж үзэж байгаа юм.

✓ Журмын 2.1.6 дахь хэсэгт “тэнсэгдсэн этгээдийг” гэж нэмэлт оруулах шаардлагатай юм. Тэнсэгдсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь тухайн этгээд шүүхээс даалгасан үүргийг биелүүлэх, эрхийн хязгаарлалтад хяналт тавихаас гадна хамгийн гол зүйл нь дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх явдал байх тул шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад Цагдаагийн байгууллага үндсэн чиг үүргээ зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай учир эл заалтыг нэмж тусгах шаардлагатай байна.

✓ Журмын 2.5 дахь хэсэгт шийдвэр гүйцэтгэгчээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд холбогдох баримт материалыг ямар хугацаанд Цагдаагийн алба хаагчид хүргүүлэхтэй холбоотой заалтыг тодорхой болгох шаардлагатай. Мөн цагдаагийн алба хаагч ямар хугацаанд хяналт тавих асуудлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон журамд тодорхойлоогүй нь мөн л хуулийн хийдэл гэж үзэх үндэслэлийг бүрдүүлж байна.

---00---